



УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

НҮҮРСЭН ГАЛЛАГААТАЙ ЗУУХНААС ХИЙН ГАЛЛАГААТАЙ ЗУУХ РУУ ШИЛЖИХ БОДЛОГО

Улаанбаатар хот

2022 он





Үндэслэл


- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 189 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Шадар сайдын 2020 оны “Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай” 123 дугаар тушаал, 2021 оны “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 89 дүгээр тушаал;
- Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 дугаар захирамж;





Халаалтын зуухны байршил

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд 100кВт-аас дээш 645, 15-100кВт-ын хүчин чадалтай 2237 зуух байв.






МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 62 ДУГААР ТОГТООЛ, МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН 2020 ОНЫ 123 ДУГААР ТУШААЛ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2019 ОНЫ А/1377 ДУГААР ЗАХИРАМЖИЙН ХҮРЭЭНД 2019-2021 ОНЫ ХООРОНД ХИЙСЭН АЖИЛУУД

2019 онд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 23 ААН-ийн 241 халаалтын зуух, тусгай зөвшөөрөлгүй 279 ААН-ийн 404 халаалтын зуух буюу нийт 302 ААН-ийн 645 халаалтын зуух байснаас төвлөрсөн дулаанд 38, Цахилгаан халаалтад 28, Хийн халаалтад 8 зуухыг холбож 16889 тн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон байна.

2020 онд тусгай зөвшөөрөлтэй 21 ААН-ийн 214 халаалтын зуух, тусгай зөвшөөрөлгүй 239 ААН-ийн 343 халаалтын зуух буюу нийт 276 ААН-ийн 558 халаалтын зуухнаас төвлөрсөн дулаанд 31, Цахилгаан халаалтад 16, Хийн халаалтад 45, сайжруулсан түлшинд 174, Баяжуулсан нүүрс /мидлинг/ 66 халаалтын зуухыг шилжүүлж 64650 тн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон байна.


2021 онд тусгай зөвшөөрөлтэй **20** ААН-ийн **182** халаалтын зуух түүхий нүүрс, тусгай зөвшөөрөлгүй 66 ААН-ийн 82 халаалтын зуух баяжуулсан нүүрс /мидлинг/ хэрэглэж байна. ОББҮХ-ны санхүүжилтээр 13 байршлын 26 зуухыг хийн халаалтад, 1 байршлын 3 зуухыг цахилгаан халаалтад, 62 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 65 зуух, 81 барилга байгууламжийг төвлөрсөн дулаан ханамжид тус тус холбож 25000 тн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон.







ТОГТООЛЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ




Тусгай зөвшөөрөлтэй	20 ААН	182 Халаалтын зуух(түүхий нүүрс)
Тусгай зөвшөөрөлгүй	68 ААН	86 технологийн зуух (мидленг)

106539 тн түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон



СҮҮЛИЙН 4 ЖИЛД АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН



2022 онд зогсоохоор төлөвлөсөн зуух:

1. БЗД-ийн 16,19,24-р хороо, Газарчин Дс орчмын өргөтгөл, шинэчлэлтийн ажилтай уялдуулан үлдсэн Трант ХХК, Дако ХХК, Трансбус ХХК орчмын $Q=3.34$ Гкал/ц-ийн дулааны ачаалал бүхий **26** барилгыг холбож, **10** ширхэг халаалтын зуухны ажиллагааг зогсооно.

2. БЗД-ийн 12-р хороо, Жанжин клуб, 20-р цэцэрлэг орчмын халаалтын зуухтай $Q=0.88$ Гкал/ц-ийн ачаалалтай **4** барилгыг холбож, **4** ширхэг халаалтын зуухны ажиллагааг зогсооно.

3. СХД-ийн 30,31-р хороо, Хилчин хотхоны $Q=1.6$ Гкал/ц-ийн ачаалалтай **120** ш АОС, барилгыг холбож **120** ширхэг халаалтын зуухны ажиллагааг зогсооно.

Эдгээр зуухнуудад шатааж байсан түүхий нүүрсний хэрэглээ нийт дүнгээр жилд **147634 тонн-оор**, агаарт хаягдах хорт хаягдлын хэмжээг нийт дүнгээр **7552 тонн-оор** тус тус бууруулж агаар, орчны бохирдлыг тодорхой хэмжээнд арилгасан үр дүнтэй ажлыг хийж гүйцэтгэсэн байна.





Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Байгаль орчин аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020.10.28-ны өдрийн 3 дугаар хуралдаанд төвлөрсөн дулаанд холбогдох боломжтой гэр хорооллын төр, орон нутгийн өмчийн барилга байгууламжийн түүхий нүүрс **хэрэглэдэг 36 халаалтын зуухыг** төвлөрсөн дулаан хангамжид холбох тооцоо, судалгааг танилцуулж **3.5 тэрбум** төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020.11.11-ний өдрийн “Эрх шилжүүлэх, хөрөнгө гаргах тухай” А/639 дүгээр тушаалаар нийслэлд шилжүүлэн. НЗД-ын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” А/1322 дугаар захирамжаар тус албанд шилжүүлсний дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерин 2020.12.25-ны өдрийн А/365 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулж дараах 4 ажлыг хийж гүйцэтгэсэн байна



2 Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа 421 дүгээр нээлттэй хорих ангийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг бүрэн дуусгаж хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангасан байна.

4 Баянзүрх дүүргийн 8, 16, 19 дүгээр хороо, Газарчин, Эрдэнэ-Толгой орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох 1, 2-р хэлхээний Ф250-300 мм-ийн голчтой хос дулааны шугам, Ус дулаан дамжуулах 2-р төвд 10Гкал/ц-ийн хүчин чадалтай халаалтын цогц төхөөрөмжийг шинээр угсарч хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангасан байна.

Хан Уул дүүргийн 5 дугаар хороо, 41-р сургууль, 29, 71-р цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг бүрэн дуусгаж хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангасан байна.

1




3

Хан-Уул дүүргийн 7, 8 дугаар хороо, 60, 118 дугаар сургууль, 209, 73 дугаар цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох дулаан дамжуулах төвийн барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангасан байна.





Эх үүсвэр, хамрах хүрээ





УУРЫН ЗУУХ АШИГЛАЖ, УЛИРЛЫН ЧАНАРТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НҮҮРСНИЙ ТЕХНОЛОГИЙН ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Нам даралтын халаалтын зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 дугаар захирамж гарсантай холбогдуулан технологийн зуухтай барилгын материал бетон эдлэл үйлдвэрлэгч, мах боловсруулах зориулалттай бөгөөд нэгэн зэрэг 200С⁰ температур, 8-16 ата даралтыг гаргадаг уур үйлдвэрлэгч **66** ААН-ийн **82** зуухны хийц бүтэц, даралт, температурын горимд тохируулан сайжруулсан түлш хэрэглэх туршилт судалгаа хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн багш нартай хамтран Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2020 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн А/91 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан сайжруулсан түлшний нунтаг, сайжруулсан түлш, баяжуулсан нүүрс гэсэн 3 төрлийн түлшийг 7 төрлийн 9 зууханд 2020 оны 04 дүгээр сарын 03-наас 12-ний өдөр хүртэл 10 хоногийн хугацаанд туршилт явуулж, баяжуулсан нүүрс хамгийн тохиромжтой гэсэн дүгнэлтийг ажлын хэсэг гаргаж НЗД-ын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлсэн.



Монгол улсын засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 50 дугаар хуралдаанд Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн нам даралтын халаалтын техникийн шийдэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулан хуралдааны тэмдэглэлээр Монгол улсын Шатар сайдад тус асуудлыг судалж танилцуулах үүрэг өгсний дагуу 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/99 тоот **Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын тушаалаар ажлын хэсэг байгуулан** тус албаны зүгээс гаргасан техникийн шийдэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг судалж үзээд технологийн уур үйлдвэрлэж зууханд хамгийн тохиромжтой түүхий эд нь баяжуулсан нүүрс / **Мидлинг** / гэсэн дүгнэлт гаргасан.




МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН 2020 ОНЫ 123 ДУГААР ТУШААЛЫН ХҮРЭЭНД ХИЙХ АЖИЛ

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд дулааны 2, 3, 4, Амгалан, Сэлбэ дэд төвийн дулааны станцаас бусад түүхий нүүрс түлж дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуухыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс болон хагас боловсруулсан нүүрс /мидлинг/ хэрэглэхийг хориглосон байна.

Дээрх шийдвэртэй холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн, багш нар болон уур үйлдвэрлэгч ААН, “Үндэсний технологийн уур үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-ын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдан технологийн уур үйлдвэрлэгч 68 ААН-ийн зуухны техникийн шийдлийг өөрчилж 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн сайжруулсан түлш хэрэглэх судалгааны ажлыг эхлүүлэх.

Тусгай зөвшөөрөлтэй	20 ААН	182 Халаалтын зуух(түүхий нүүрс)
Тусгай зөвшөөрөлгүй	66 ААН	82 технологийн зуух (мидленг)


Тусгай зөвшөөрөлтэй 20 ААН, 182 халаалтын зуух, Тусгай зөвшөөрөлгүй 66 ААН, 82 халаалтын зуухны технологийн өөрчилөлт хийх судалгааг танилцуулах албан тоот хүргүүлсэн.





Техникийн шийдэл


д/д	Түлшний төрөл	Зуухны хүчин чадал	Түлш хэмжих нэгж	Түлшний нэгж үнэ.төг	Түлш зарцуулалт буюу зардлын тооцоо			
					1 цагт	16 цагт буюу 1 хоногт	30 хоног буюу 1 сард	240 хоног буюу 1 жилд
1	Түүхий нүүрс	700кВт 0.7 МВт	кг	75	180	2 880	86 400	691 200
		13 500			216 000	6 480 000	51 840 000	
		360			5 760	172 800	1 382 400	
		27 000			432 000	12 960 000	103 680 000	
		464			7 424	222 720	1 781 760	
		1800 кВт 1.8 МВт			34 800	556 800	16 704 000	133 632 000
2	Цахилгаан	700кВт 0.7 МВт	кВт	152	700	11 600	336 000	2 688 000
		106 400			1 702 400	51 072 000	408 576 000	
		1 400			22 400	672 000	5 376 000	
		212 800			3 404 800	102 144 000	817 152 000	
		1 800			28 800	864 000	6 912 000	
		1800 кВт 1.8 МВт			273 600	4 377 600	131 328 000	1 050 624 000
3	Хийн түлш	700кВт 0.7 МВт	кг	2950	52	832	24 960	199 680
		153 400			2 454 400	73 632 000	589 056 000	
		102			1 632	48 960	391 680	
		300 900			4 814 400	144 432 000	1 155 456 000	
		150			2 400	72 000	576 000	
		1800 кВт 1.8 МВт			442 500	7 080 000	212 400 000	1 699 200 000





ПАТЕНТТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

- Хатуу түлш нь 100 хувийн гүйцэт шаталт бий болгоно.
- Агаарт дэгдэх хорт утааг нь 100 хувь үгүй болно.
- Хатуу түлшний бүрэн шаталтаас үнс хог хаягдал гарахгүй.
- Гар ажиллагаа байхгүй болж 100 хувь автомат мэдрэгчээр удирдах.
- Ямар ч төрлийн зуухны аман дээр байрлуулж болох.
- Улаанбаатар хотод мөрдөгдөж байгаа стандартын шаардлага хангасан хатуу түлшний шинж чанраас үл хамааран түлшийг нунтаглан шууд хэрэглэж болдгоороо онцлогтой.





ДҮГНЭЛТ

МОНГОЛ УЛС
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

АШИГТАЙ ЗАГВАРЫН
ПАТЕНТ

Монгол Улсын Оюуны өмчийн газрын дарга 2022 оны 2 сарын 24-ний өдөр /нөхөн А/25 тоот тушаалаар ашигтай загварыг эзэмших эрхийг эзэмшүүлж өгсөн байна.

Ашигтай загварын нэр:	Бүрэн шилэгтэй хатуу түлш шатаагч төхөөрөмж
Удсан бүртгэлийн дугаар:	20-0005422
Мэдээллийн бүртгэлийн дугаар:	20-2022-0004584
Авчлагч өмч:	2022.02.18
Зохлогчийн нэр:	Алибаши ТӨГТӨХ
Эзэмшгчийн нэр:	Алибаши ТӨГТӨХ
Хүчинтэй хугацаа:	2032.02.18

ДАРГА  АЛИБАШИ САЙХАН



000002338

- Нүүрсний техникийн шинжилгээнээс харахад сайжруулсан түлшний дэгдэмхий эд стандарт утгаас 1.16 дахин, баяжуулсан нүүрснийх 1.07 дахин их, бусад үзүүлэлтүүд нь стандарт утгыг бүрэн хангаж байна.
- Сайжруулсан шахмал түлшний хувьд өнөөдөр **стандарт, шаардлагад нийцсэн түлш хэмээн хүлээн зөвшөөрөгдөн иргэд, аж ахуйн нэгжүүд албан ёсоор ашиглаж байгаа бөгөөд** энд ганц асуудал үүсгэж байгаа нь түүний шаталтаас үүсэх утааны хийд агуулагдах **хүхрийн ислийн агууламжийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд** байгаа юм. Учир нь Баяжуулсан нүүрс нь Сайжруулсан түлшний түүхий эдийн 95%-ийг бүрдүүлдэг.
- Сайжруулсан шахмал түлшний MNS5679:2019 стандартын шаардлагыг Баяжуулсан нүүрсний үзүүлэлтүүд хангаж байгаа тул хүхрийн ислийг бууруулах аргыг хэрэглэснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багасаж, тухайн үйлдвэрүүд нь ашиглах боломжтой байна.
- Хий халаалтад шилжүүлэхэд анхны хөрөнгө оруулалт болон ашиглалтын зардал нүүрс болон мидлингээс 4-6 дахин их байхаар байна. /иргэн аж ахуйн нэгжийн халаатын үнэ 4-6 дахин нэмэгдэх/



УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

АНХААРАЛ ТАВЬСАН БАЯРЛАЛАА

